



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: СБА-2022/69/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт 2022 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Ганцэцэг Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518398, Факс: 70518398  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СоЛл, 02, 25 № 69  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН АСГАТ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Б.СУМЪЯАСҮРЭН ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>26,001,689.36</u></b>	<b><u>164,128,876.26</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	884,688.36
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	884,688.36
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	884,688.36
31211	Төрийн сангийн харилцах	00.00	7,533.36
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	877,155.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	100,839,500.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	100,839,500.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	100,839,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	26,001,689.36	62,404,687.90
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	12,115,577.36	30,789,598.70
35110	Тусгай зориулалттай материал	8,528,462.00	9,495,355.00
35130	Эм боох материал	3,587,115.36	21,294,243.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,411,112.00	26,965,089.20
35410	Бичиг хэргийн материал	30,000.00	3,533,700.00
35420	Аж ахуйн материал	4,370,630.00	3,838,300.00
35440	Түлш, шатах тослох материал	1,105,420.00	2,752,268.00
35450	Барилгын засварын материал	85,000.00	50,000.00
35460	Хүнсний материал	2,110,162.00	2,986,971.20
35470	Бусад хангамжийн материал	2,709,900.00	13,803,850.00
35600	Мал амьтад	3,475,000.00	4,650,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>443,601,121.24</u></b>	<b><u>477,492,901.55</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	443,601,121.24	477,492,901.55
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	432,103,121.24	465,994,901.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	365,471,416.58	365,471,416.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,825,707.40	-35,421,342.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,347,183.00	61,347,183.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-37,164,246.43	-40,557,183.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,847,096.98	120,012,040.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78,604,513.53	-74,435,698.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,881,644.35	49,979,329.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,934,310.35	-42,777,714.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	64,711,000.00	95,464,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-28,626,441.96	-33,087,629.52
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	11,498,000.00	11,498,000.00
39301	Програм хангамж	1,219,500.00	1,219,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,219,500.00	-1,219,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,498,000.00	11,498,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>469,602,810.60</u></b>	<b><u>641,621,777.81</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>469,602,810.60</u></b>	<b><u>641,621,777.81</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	469,602,810.60	641,621,777.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	429,266,250.98	429,266,250.98
51101	Өмч: - төрийн	429,266,250.98	429,266,250.98

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	40,336,559.62	212,355,526.83
51210	Өмнөх үеийн үр дүн	40,336,559.62	40,336,559.62
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	172,018,967.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>469,602,810.60</u></b>	<b><u>641,621,777.81</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>362,503,152.32</b>	<b>772,876,142.16</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,375,655.32</b>	<b>79,215,615.16</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,375,655.32	79,215,615.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,375,655.32	79,215,615.16
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,375,655.32	79,215,615.16
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>42,836,597.00</b>	<b>315,048,527.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	310,290,900.00	378,612,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,924,535.00	271,653,627.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	2,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,799,435.00	266,671,927.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	125,100.00	2,431,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	17,713,000.00	28,367,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,713,000.00	28,367,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	15,199,062.00	15,027,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,199,062.00	15,027,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>391,082,710.44</b>	<b>600,726,675.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>391,082,710.44</b>	<b>600,726,675.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	389,021,809.96	560,783,146.16
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	231,951,153.05	297,076,717.14
210101	Үндсэн цалин	171,942,376.32	166,261,939.69
210102	Нэмэгдэл	53,672,006.53	76,002,989.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,222,000.00
210104	Урамшуулал	6,336,770.20	51,589,787.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,362,453.47	35,474,004.50
210201	Тэтгэврийн даатгал	21,118,920.31	25,822,104.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,356,579.29	2,459,015.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,844,743.02	1,926,812.51
210204	Ажилгүйдлийн даатгал	458,418.82	478,797.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,583,792.03	4,787,274.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,268,576.00	15,294,700.87
210301	Гэрэл, цахилгаан	6,061,590.00	6,619,334.87
210302	Түлш, халаалт	7,206,986.00	8,675,366.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,243,665.00	21,417,828.00
210401	Бичиг хэрэг	2,517,955.00	3,698,095.00
210402	Тээвэр, шатахуун	13,059,560.00	15,453,613.00

**Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,134,000.00	1,290,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	532,150.00	976,120.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,627,637.96</b>	<b>120,039,375.06</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,401,167.96	104,079,474.26
210502	Хоол, хүнс	4,980,370.00	11,576,580.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,246,100.00	4,383,320.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,717,044.00</b>	<b>16,055,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,902,900.00	6,163,300.00
210602	Тавилга	00.00	157,350.00
210604	Урсгал засвар	3,814,144.00	9,735,050.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>446,500.00</b>	<b>154,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	446,500.00	154,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>14,705,680.00</b>	<b>15,579,983.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,590,700.00	15,579,983.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	114,980.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,699,100.48</b>	<b>39,690,837.59</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,696,000.00	2,499,460.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,003,100.48	37,191,377.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,060,900.48</b>	<b>39,943,529.13</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,020,000.00</b>	<b>32,430,950.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,020,000.00	32,430,950.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>40,900.48</b>	<b>7,512,579.13</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,900.48	7,512,579.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-28,579,558.12</b>	<b>172,149,466.87</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>130,499.66</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	130,499.66
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-130,499.66</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-28,579,558.12</b>	<b>172,018,967.21</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,266,250.98	00.00	40,336,559.62	00.00	469,602,810.60
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,266,250.98	00.00	40,336,559.62	00.00	469,602,810.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,266,250.98	00.00	40,336,559.62	00.00	469,602,810.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	172,018,967.21	00.00	172,018,967.21
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,266,250.98	00.00	212,355,526.83	00.00	641,621,777.81

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>353,127,497.00</u></b>	<b><u>633,921,027.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>353,127,497.00</b>	<b>633,921,027.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	310,290,900.00	378,612,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,924,535.00</b>	<b>211,914,127.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	2,550,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,799,435.00	206,932,427.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	125,100.00	2,431,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>17,713,000.00</b>	<b>28,367,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	17,713,000.00	28,367,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>15,199,062.00</b>	<b>15,027,500.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	15,199,062.00	15,027,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>353,127,497.00</u></b>	<b><u>588,967,838.64</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>353,127,497.00</b>	<b>588,967,838.64</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>351,066,596.52</b>	<b>549,024,309.51</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>231,951,153.05</b>	<b>297,076,717.14</b>
210101	Үндсэн цалин	171,942,376.32	166,261,939.69
210102	Нэмэгдэл	53,672,006.53	76,002,989.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	3,222,000.00
210104	Урамшуулал	6,336,770.20	51,589,787.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,362,453.47</b>	<b>35,474,004.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,118,920.31	25,822,104.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,356,579.29	2,459,015.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,844,743.02	1,926,812.51
210204	Ажилгүйдлийн даатгал	458,418.82	478,797.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,583,792.03	4,787,274.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,713,856.00</b>	<b>15,854,820.87</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,061,590.00	6,619,334.87
210302	Түлш, халаалт	7,652,266.00	9,235,486.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,933,805.00</b>	<b>25,624,715.00</b>
210401	Бичиг хэрэг	2,547,955.00	7,201,795.00
210402	Тээвэр, шатахуун	13,719,700.00	16,156,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,134,000.00	1,290,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	532,150.00	976,120.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,618,105.00</b>	<b>92,411,959.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,832,035.00	73,416,579.00
210502	Хоол, хүнс	4,800,000.00	9,488,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,986,070.00	9,506,990.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,059,044.00	62,848,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,059,900.00	47,780,900.00
210602	Тавилга	00.00	1,078,300.00
210604	Урсгал засвар	3,999,144.00	13,989,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	446,500.00	154,000.00
210702	Дотоод албан томилолт	446,500.00	154,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,705,680.00	15,579,983.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,590,700.00	15,579,983.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	114,980.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,276,000.00	3,999,460.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,276,000.00	3,999,460.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,060,900.48</b>	<b>39,943,529.13</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,020,000.00	32,430,950.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,020,000.00	32,430,950.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	40,900.48	7,512,579.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,900.48	7,512,579.13
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>44,953,188.36</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>44,068,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>44,068,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	44,068,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	44,068,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-44,068,500.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	884,688.36
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	884,688.36

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	426,800,600.00	414,486,787.51
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	426,800,600.00	414,486,787.51
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	422,568,800.00	410,255,837.51
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	279,161,200.00	278,082,625.14
210101	Үндсэн цалин	174,294,100.00	166,261,939.69
210102	Нэмэгдэл	75,831,200.00	76,002,989.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,980,000.00	3,222,000.00
210104	Урамшуулал	24,055,900.00	32,595,695.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,805,000.00	35,474,004.50
210201	Тэтгэврийн даатгал	26,603,600.00	25,822,104.41

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	2,800,200.00	2,459,015.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,240,200.00	1,926,812.51
210204	Ажилгүйдлийн даатгал	560,200.00	478,797.45
210205	Эрүүл мэндийн даатгал	5,600,800.00	4,787,274.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,367,400.00</b>	<b>15,854,820.87</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,022,400.00	6,619,334.87
210302	Түлш, халаалт	16,345,000.00	9,235,486.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,164,000.00</b>	<b>20,069,635.00</b>
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	3,203,515.00
210402	Тээвэр, шатахуун	14,600,000.00	14,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,564,000.00	1,290,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	976,120.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>31,531,000.00</b>	<b>31,110,409.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,593,400.00	22,355,689.00
210502	Хоол, хүнс	5,689,300.00	5,689,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,248,300.00	3,065,420.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,772,500.00</b>	<b>10,430,900.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,772,500.00	4,476,400.00
210602	Тавилга	1,000,000.00	954,500.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>650,000.00</b>	<b>154,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	650,000.00	154,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,117,700.00</b>	<b>15,079,983.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,117,700.00	15,079,983.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4000000.00</b>	<b>3999460.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	3,999,460.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4231800.00</b>	<b>4230950.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,231,800.00</b>	<b>4,230,950.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,231,800.00	4,230,950.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>433,752,531.00</b>	<b>422,006,900.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>378,612,000.00</b>	<b>378,612,000.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	378,612,000.00	378,612,000.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>35,139,800.00</b>	<b>28,367,400.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	35,139,800.00	28,367,400.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>20,000,731.00</b>	<b>15,027,500.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,000,731.00	15,027,500.00
122002	Хандив тусламж /гадаад/		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>22</b>	<b>23</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16
620003	Үйлчлэх ажилтан	6	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>211,036,972.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>211,036,972.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	182,836,972.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	18,994,092.00
210104	Урамшуулал	18,994,092.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,555,080.00
210401	Бичиг хэрэг	3,998,280.00
210402	Тээвэр, шатахуун	1,556,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	61,301,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	51,060,890.00
210502	Хоол, хүнс	3,799,090.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,441,570.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	95,486,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	73,498,300.00
210602	Тавилга	11,300,000.00
210604	Урсгал засвар	10,687,950.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	28200000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,200,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	188025427.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	188,025,427.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,050,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	183,043,727.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,931,700.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц

бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, шилэн данс, хүлээн аваагүй үндсэн хөрөнгө данс бүртгэлд тусгасантай холбоотой өгсөн төлбөрийн акт, зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэн бүрд чанартай, аюулгүй, хүртээмжтэй амьдралын чанарыг сайжруулан хүн амын дундаж наслалтыг уртасгахад оршино.” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 384.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 172.02 сая төгрөгөөр буюу 36.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0.9	0.9
Авлага	0.00	100.8	100.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	-	-
Бараа материал	26.0	62.4	36.4
Үндсэн хөрөнгө	443.6	477.5	33.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>469.6</b>	<b>641.6</b>	<b>172.0</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	469.6	641.6	172.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>469.6</b>	<b>641.6</b>	<b>172.0</b>

Авлага дансны үлдэгдэл 100.8 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын улмаас хэвтэн эмчлүүлэгчдийн төлбөр 59.7 сая, “Мед буян” ХХК-аас худалдан авсан үндсэн хөрөнгийн авлага 41.1 сая, нийт 100.8 сая төгрөгийн авлага үүссэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 477.49 сая төгрөг болж 33.89 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн данс өсөхөд төсвийн хөрөнгөөр 43.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 27.1 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан нь гол нөлөөлжээ.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 410.4 сая төгрөгөөр буюу 113.2 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан туслах үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайлант онд ковид-19 цар тахалтай холбоотойгоор туслах үйл ажиллагааны орлого 256.8 сая төгрөгөөр

өссөн байна. Харин үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 69.8 сая төгрөгөөр өсөж, тайлант үед 79.2 сая төгрөг болсон байна. Энэ нь 52.1 сая төгрөгийн материал, 27.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 79.2 сая төгрөгийн хөрөнгө, материал үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 209.6 сая төгрөгөөр буюу 53.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урамшуулал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, багаж, техник хэрэгсэл, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зэрэг зардлууд байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой эмч, эмнэлгийн ажилчдын илүү цагийн хөлс, Эрүүл мэндийн сайдын тушаалаар олгогдсон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, цар тахлын үед халдвар хамгааллын дэглэм сахихтай холбоотой зэргээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 579.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 578.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 151.7 сая төгрөгөөр бууруулж 426.8 сая төгрөгөөр баталсан байна. Төсөв нь 151.7 сая төгрөгөөр хасагдсан боловч тухайн байгууллагын 2021 онд хэрэгжүүлэх 10 зорилт, 92 арга хэмжээ бүхий “Гүйцэтгэлийн төлөвлөгөө” 87 хувьтай хэрэгжсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 426.8 сая төгрөгийн төсөв баталснаас 378.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 28.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 19.8 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 378.6 сая, орон нутгийн төсвөөс 28.0 сая төгрөгийн санхүүжилт авч, эрүүл мэндийн даатгалын сангаас 15.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 414.5 сая төгрөгийг зарцуулж, 7.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 0.007 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 211.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 211.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 0.9 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төв ковид19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн даатгалын сангаас 59.7 сая, үндсэн хөрөнгө худалдан авсан боловч тайлант онд хөрөнгөө хүлээн аваагүй 41.1 сая нийт 100.8 сая төгрөгийн авлагатай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний хэрэгжилт 87 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97 хувийн биелэлттэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа хоцорсон 4 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 0.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 6 сарын 25-ны өдөр албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

- Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 0.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг нөхөн олгосон;
- Нүүрсний тээврийн хөлсийг илүү тооцож олгосон 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг төлүүлсэн;
- Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс 26 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн албан шаардлагын дагуу хэрэгжүүлэн ажилласан;
- Төсвийн төслийг аргачлал, заавар журам, төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, хэвших зөвлөмжийг хэрэгжүүлсэн;

- Дээд шатны байгууллага болон эрх бүхий этгээд дотоод хяналтын журмыг батлаагүй бол Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн гэж үзлээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Асгат сумын Эрүүл мэндийн төвийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 603.1 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 44.4 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 599.5 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

- Нэг сая төгрөгийн үнэ бүхий хүндэтгэлийн булан хийлгэж шууд зардалд тайлагнасан;
- Үндсэн хөрөнгийн тооллогоор хандиваар хүлээн авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Үндсэн хөрөнгийн тооллогыг тулгахад бодитоор байхгүй 41.1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгын “үнэн зөв байдал”, “тодруулга ба толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд тусгасан 1.0 сая төгрөгийн зардлыг уг дүнгээр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн залруулсан.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан шээсний шинжилгээний аппаратыг зах зээлийн үнээр үнэлэн 2.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгөнд залруулга хийлгэв.
- Хүлээн аваагүй 41.1 сая төгрөгийн хөрөнгийг авлага дансанд бүртгэн залруулга хийв.

### 4.2 Төлбөрийн акт

- Сахилгын шийтгэлийн хугацаа дуусаагүй албан хаагчид үр дүнгийн урамшуулал 0.3 сая төгрөг олгож, төсвийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 /Ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй./, 131 дүгээр зүйлийн 131.4 /Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно/, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.3/ Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд

хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно./, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

#### **4.3 Албан шаардлага**

Тооллогын комисс эд хөрөнгө нэг бүрийг үзэж, үнэн зөв бодитой тооллого хийгээгүй, тооллогын дүнг нягтлан бодогчтой тулгаж баталгаажуулаагүй нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1 /тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих/, 72.4.2 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/, 72.4.4 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ дахь заалттай нийцэхгүй байна.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

###### **1.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 151 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

###### **1.1Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

##### **2. Шилэн данстай холбоотой асуудал**

###### **Илрүүлэлт**

Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээллээс 22 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ нийт 701.9 сая төгрөгийн 31 мэдээллийг ил тод байршуулахаас 10.2 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчил илэрсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж**

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төв	7	44.6	3	44.3	1	0.3	1	0	2	0